

ТҮМЭНЦОГТ СУМЫН 2022 ОНЫ 02 ДҮГЭЭР САРД ХИЙСЭН АЖЛЫН МЭДЭЭ

Төрийн удирдлагын чиглэлээр:

Засаг даргын захирамж 3, ЗДТГ-ын даргын тушаал 0, Засаг даргын ирсэн бичиг-11, Засаг даргын явсан бичиг-24, ЗДТГ-ын даргын ирсэн бичиг-2, явсан бичиг-0, өргөдөл гомдол-0, Төрийн үйлчилгээний оператороос төрлийн лавлагаа өгч иргэн төвтэй-төрийн үйлчилгээг хүргэн ажиллаж байна.

Хөрөнгө оруулалт, Дэд бүтэц, Байгаль орчин, Хөдөө аж ахуйн чиглэлээр:

1. Бод, бог малын зохиомол хээлтүүлгийн техникч бэлтгэх сургалтанд хамрагдах хүмүүсийн захиалгыг ХХААГ-т хүргүүлсэн
2. Зохиомол хээлтүүлэгт хамрагдах хээлтэгч малын судалгаа гаргаж ХХААГ-т хүргүүлсэн

Мал эмнэлгийн тасаг:

1. Түмэнцогт сумын нутаг Хөхүүрт, гэх газар гоц халдварт шүлхий өвчний сэжигтэй дуудлага ирсэн тул лабораторийн шинжилгээгээр баталгаажих хүртэлх хугацаанд тухайн газар хязгаарлалтын дэглэмийг 2022 оны 02 дугаар сарын 08-ны өдрөөс эхлэн хязгаарлалт тогтоосон
2. Малын гоц халдварт өвчний шинж тэмдэг илрэн улсын төв лабораторийн шинжилгээгээр баталгаажин 2022.02.14-нөөс 28 хонгийн хугацаатай хорио цээрийн захирамж гаран ажиллаж байна мөн тухайн голомттой бүсэд суурин пост 14 хүний бүрэлдэхүүнтэй гарч байна.
3. Мал амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх санамж, зөвөлгөөг сумын хил залгаа өвөлжиж байгаа өөр аймаг сум болон өөрийн аймаг сумын малчидтай нутаглаж байгаа малчид, мал бүхий иргэдэд мэдээ мэдээлэл хүргэн ажиллаа.
4. Малын гоц халдварт шүлхий өвчин одоогоор нэмэгдсэн болон дуудлага ирсэн малчин байхгүй байна.

Хууль эрх зүйн чиглэлээр:

Ковид-19 цар цахалтай холбоотой Улсын Онцгой комиссын албан даалгавар, ЗГ-ын тогтоол, аймгийн Засаг даргын захирамжийн хүрээнд холбогдох арга хэмжээг авч цахимаар 24 төрлийн мэдээллийг сумын 3 группээр дамжуулан иргэдэд хүргэсэн. Шинэчлэгдэн найруулагдсан хууль тогтоомжийн талаарх мэдээ, мэдээллийг олон нийтэд цахимаар 3 төрлийн мэдээлэл 20 гаруй удаагийн давтамжтай хүргэсэн. Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах орон тооны бус зөвлөл байгуулж худалдаа үйлчилгээ эрхэлдэг ААНэгжүүдэд хяналт тавьж, заавар зөвлөмж, сургалт зохион байгуулах төлөвлөгөө гарган ажиллаж байна. Шүлхий өвчин гарсантай холбоотой хөл хорио хэсэгчлэн тогтоож түүнд хяналт тавьж байна.

Нийгмийн бодлогын чиглэлээр:

1. Сүхбаатар аймгийн гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газраас чиглэл ирүүлсний дагуу Хүүхэд хамгааллын статистик үзүүлэлтийг гарган хүргүүллээ.
 - ✓ 2021 оны хүүхдийн тоо 861 үүнээс эмэгтэй-426
 - ✓ Шинээр төрсөн хүүхдийн тоо-59
 - ✓ Хүүхэд хамгааллын хамтарсан багийн үйлчилгээнд хамрагдсан тохиолдлын хүүхдийн тоо-3
 - ✓ Хүүхэд хамгааллын үйлчилгээнд хамрагдсан хохирогч хүүхдийн тоо-1
 - ✓ Дотуур байранд амьдарч буй хүүхдийн тоо-41
 - ✓ Бүтэн өнчин хүүхдийн тоо-1
 - ✓ Хагас өнчин хүүхдийн тоо-29
 - ✓ Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо-9Хурдан морь унаач хүүхдийн тоо-42
2. Хүүхдийн хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдлыг хангах хүрээнд энэ оны хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг сумын Засаг даргаар батлуулан Засаг даргын 2022оны 02 сарын 18-ний өдрийн 04 албан тоотоор ЕБС-ийн захирал, багийн Засаг дарга нарт хэрэгжүүлж ажиллах талаар чиглэл өгч хүргүүлэв.
3. Сумын Залуучуудын салбар зөвлөлийн мэдээлэл, гишүүдийн анкетыг аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын газарт хүргүүлэв.
4. Алдарт эхийн одон авах 7 эхийн материал, одон гээгдүүлсэн дахин авах 1 эхийн материал хүлээн авсан.

Нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлт, Боловсрол, Соёл, Эрүүл мэндийн чиглэлээр: Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр:

Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр:

Ажил хайгч 2 иргэдийн мэдээллийг “LIMS” праграммд шинэчилж бүртгэсэн.

Ажлын байраар хангагдсан 2 иргэнийг ажил зуучлалаар мэдээллийн санд бүртгэсэн.

Санхүүгийн дэмжлэгт хамрагдсан ...1.. иргэний ..150000... төгрөгний эргэн төлөлтийг төвлөрүүлсэн.

Нийгмийн халамжийн чиглэлээр:

1. Хүнсний эрхийн бичгийн олголттой холбоотой хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ үзүүлж байгаа дэлгүүрийн прагромм хөгжүүлэлтийг хийлгэж 2 сарын 22 өрхийн олголтын жагсаалтыг хүнсний дэлгүүр гаргаж өгсөн.
2. Хөгжүүлэх өрх, амьжиргааг дэмжих өрх болон халамжаас хөдөлмөрт шилжүүлэх өрх иргэний тоон судалгааг Хүнсний эрхийн бичиг хариуцсан мэргэжилтэнд гаргаж өгсөн.
3. 2 сарын нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмжийн олголтын тулгалтыг хийж нийгмийн даатгал шилжсэн 1 иргэн мөнгөн дүнг таталт хийлгэн 3 иргэний мөнгөн дүнг нэмэлт жагсаалтаар өгсөн.
4. 2022.02.21 онлайн хурал хийж 3 асуудалыг хэлэлцсэн

5. 2022.03.08-ны өдөр буюу эмэгтэйчүүдийн баярыг тохиолдуулан амьжиргааг дэмжих зөвлөлтөй хамтран хэвтэрт байнгын асаргаанд байгаа ахмадуудад өөрийн мэргэжил ур чадварын хүрээнд бариа заслийн эмчилгээг хийж үйлчилнэ.
6. Амьжиргааг дэмжих зөвлөлийг тухайн сард 2 удаа хуралдуулж 6 төрлийн асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж холбогдох мэргэжилтэнд хурлын тэмдэглэлийг материалын хамт хүргүүлж ажилласан. Үүнд:
 1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний асаргааны тэтгэмжийн сунгалт 4 иргэн
 2. Ахмад настны асаргааны тэтгэмжид хамрагддаг 4 иргэний асаргааг сунгасан.
7. Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн тулгалтийг цаг тухай бүрт хийн нөхөн олголтыг холбогдох мэргэжилтэнд хүргүүлж ажиллаж байна.

2 сарын тэтгэвэр тэтгэмжийн олголт:

№	Тэтгэвэр, тэтгэмжийн төрөл	Хүний тоо	Мөнгөн дүн /мян.төг/
1	Нийгмийн халамжийн тэтгэвэр	40	11520000
2	Байнгын асаргаатай ахмад, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд болон иргэн, бүтэн өнчин хүүхэд асардаг иргэний тэтгэмж	41	
3	Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай иргэд		
4	Тэжээгчээ алдсны тэтгэвэр	10	3068000
5	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөнгөлөлт тусламж	4	80000
6	Жирэмсэн эхийн тэтгэмж		
7	0-3 хүртэлх насны хүүхэд асарч байгаа эхийн тэтгэмж		
8	Гэнэтийн аюул осол урьдчилан төсөөлөх боломжгүй шалтгаанаар амьдарч байсан гэр орон нь цаашид амьдрах боломжгүй болсон болон амьжиргааны эрх үүсвэрээ алдсан 22 өрхийн материал		
9	Хүүхдийн мөнгөн тэтгэмж		
	Нийт		

Эдийн засаг, төсөв санхүүгийн бодлогын хүрээнд:

Шилэн дансны тухай хуулийн 5-р зүйлийн 5,3 дах заалтыг хэрэгжүүлэх үүднээс 2022 оны 02-р сарын мэдээг шилэн дансны вейб сайтад байршуулсан Сангийн яам болон холбогдох хэлтэс агентлагт хувиарын дагуу мэдээг хүргүүлэн ажилласан.

Татвар , нийгмийн даатгалын тайланг сайтуудад нь хугацаанд нь илгээсэн.

2021 оны санхүүгийн тайланг хуулийн хугацаанд аудитын байгууллагуудад хүргүүлсэн.

2021 оны жилийн санхүүгийн тайлан сангийн яамны сайтад цахимаар хуулийн хугацаанд илгээсэн.

2021 оны хөрөнгийн тайлан мэдээг аймгийн өмчийн албанд хүргүүлсэн.

Статистикийн хэлтэст сарын болон улирлын мэдээг хугацаанд хүргүүлсэн.

Орон нутгийн орлогын биелэлт: / 02 сарын дүнгээр мян.төг /

• Үйл ажиллагааны орлого	1054,0
• ЦХБТАОрлого	12776,0
• Шууд бус орлого	
• Малын албан татвар	3350,9
• Хөрөнгө борлуулсаны орлого	1020,0
• Хөрөнгийн орлого	6305,3
• Буу	30,0
• Улсын тэмдэгтийн хураамж	849,6
• Хог хаягдал	
• Хүү торгуулийн орлого	12777,0
• ТТАМ	150,0
• Бусад нэр заагдаагүй орлого	
• Газар	761,0
• Ан амьтны нөөц ашигласны хураамж	
• Дүн	39073,8

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:

ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Б.АРИУНЖАРГАЛ